

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

Эрдэм шинжилгээний бичиг

Боть XLI (483)

Улаанбаатар

2017

АДУУНД ХОЛБОГДОХ НЭГЭН БИЕТ БУС ӨВИЙН ХЭЛ, СОЁЛЫН СУДАЛГАА

Чой.Баттулга
Бан Корнелия

Түүхчид, эртний судлаачдын үзэж байгаагаар хүн төрөлхтөн адгуус амьтдыг гэршүүлэн гаршуулах үйл явц одоогоос 14 мянган жилийн тэртээгээс маш эрчимтэй явагдаж, 6 мянган жил үргэлжилж, 8 мянган жилийнөмнө гэрийн тэжээмэл амьтан үүссэн гэж үздэг.

Монголчууд эртнээс таван хошуу малаа адуулан, усны тунгалаг, өвсний соргогийг даган нүүдэллэж, мал сүргээ тарган тавтай өсгөн үржүүлж, малынхаа ашиг шимийг хүртсээр өнөөг хүрэхэд малчин-нүүдэлчдийн биет болоод биет бус цогц нэгдмэл соёлыг бүтээжээ. Үүнээс адуу хийгээд адууны соёлыг илүү эрхэмлэдэг байсан гэхэд гайхах зүйл үгүй юм.

Японы эрдэмтэн Гото Томидо “Монголчууд эхлэн адуу барьж тэжээсэн, XIII-XIV зууны үед монгол хүн адууны махыг үнэтэй сайн хоол гэж иддэг байсан” гэхчилэн адууг бусад малаас илүү их эрхэмлэж байсан тухай мэдээ их бий. Иймээс Юань гүрний үед Адууны засгийг тусгайлан тогтоожээ. Хааны их адуун сүргийг дээдсийн сүрэг хэмээн нээрэлж байсан бөгөөд Хубилай хааны үед “Дээдсийн адуун сүргийн яам” байгуулжээ. Тэр үед адуу шиг хэрэгцээт мал бас ховор бөгөөд дайн байлдааны асар их ач холбогдолтой мал байсан юм (Далай, 1973:98).

Бидний энэ удаа өгүүлэх зүйл бол адууны соёлд хамаарах хурдан моринд цол чимэг өгөх зан үйл, түүнтэй холбоотой үг хэллэг юм. Өөрөөр хэлбэл, Бөхийн барилдаанд амжилттай сайн барилдсан бөхөд “начин”, “харцага”, “заан”, “гаръд” “арслан”, “аварга” хэмээх цол олгож улмаар амжилт ахиулсан тохиолдолд “үнэн хүчт”, “хичээнгүй нягт”, харайлтгүй жсавхлант” гэх мэт олон чимэг олгодгийн адил хурдан морины уралдаанд түрүүлж айрагдсан, мөн цулбуур өргүүлэн барианд орсон морьдод цол, чимэг олгодог уламжлал байжээ. Энэ талаар Бадаргуулт төрийн үе, Шажин төрийг хослон баригч хаант Монгол улсын үеийн даншиг наадмыг нүдээр үзэж, бие оролцож явсан Магсаржав Хурц “Хурдан морины зууны гучин хувиар тасалж цол дуудна. Түрүүлсэн морийг бодын алдраар дуудахдаа зарлигаар өргөмжилсөн, шашныг мандуулах, амьтныг жаргуулагч Жавзандамба хутагтын гэгээн таны сүргийг *Бат мөнх төвшин сайхан шашин төрийн билэг, энэ наадмын омноос эрхэм цогийг бадруулагч, бат бардуун ирэгч олон түмний эх хэмээн дуудна*. Хоёрдугаарт орсноос эхлэн дээр дурдсан бөх барилдуулахад дэс дараалсан ноёд лам нарын алдраар дуудахад түүний сүргийг *Бадарсан сайхан шашин төрийн бат идэр хүлэг* гэх мэтээр янз янзаар цоллон дуудна. Зарим хушуу газар хоёрдугаар морины цолыг дуудахдаа *нэгийн удаа нэхэн тэмцэжс*, *аван алдажс, арай дутажс ирсэн энэ морь хэний вэ?* гэвэл тэр түүний гэж дуудаж инээдэм наадам болгож байсан нь сонирхолтой мэт үзэгдэж байлаа. Богдын сүрэг морь доор орсныг богдын алдраар дуудахгүй уяачин хүний нэрээр дуудах ба ноёдын дэс дараалсан үе өнгөрсөн хойно морины цолыг уул эздийн нэрээр дуудна. Тэргүүн таван морийг асар гурав эргүүлэн

цолыг гурвантаа дуудаж, эцсийн дуудлага дээр унасан хүүхдэд айраг боорцог хүртээж морины толгой бие билэгтэй ёсоор айраг сацна” (1960:29-30) хэмээсэн байдаг.

Харин эрдэмтэн Х.Нямбуу “Монгол ардын өрөөл магтаал” бүтээлдээ хурдан морины цолны нэрийг дурджээ. Морины цолны нэр гэдэг нь мэдээж хэрэг Монголчуудын моринд өгч ирсэн цол буй за. Үүнд:

Түрүүлсэн моринд *Баярын магнай*

Хоёрт ирсэн моринд *Жаргалант хүлэг*

Гуравт ирсэнд *Нарны мандал Сарны түшилэг*

Дөрөвт ирсэнд *Начин шонхор*

Тавд ирсэнд *Идэр заан*

Зургаад ирсэнд *Начин шонхор*

Долоод ирсэнд *Хөх арслан*

Наймд *Хүлэг жаргал*

Есд *Алтан сандал*

багтана гэсэн бол Өвөр Монголын эрдэмтэн Дамбийжалцан “Малчин ард, уралдаанд түрүүлсэн морийг *Түмний эх*, *Баярын манлай*, *Эрдэнийн хүлэг*, *Аранзал хүлэг*, *Ажсай хүлэг*, *Жигүүрт хүлэг* гэх мэтчилэн адил бусаар цоллохоос гадна, “айргийн тав” буюу цаашлаад есдүгээр байр хүртэлх моринд *Жаргалант хүлэг*, *Билгийн хээр*, *Наран мандал*, *Догшин харцага*, *Начин шонхор*, *Цагаан арслан*, *Идэр заан*, *Өлзийт хүлэг*, *Суман цагаан*, *Бүрэн жаргал*, *Тас бүргэд*, *Тоты шонхор* гэж нэршүүлэн цоллогдог. Бас адаг сүүлд ирсэн моринд *Алтан сандал*, *Өөхөн бомбөг*, *Баян ходоод* гэх мэт цол өгдөг. Уралдаан морины цол дуудахдаа тэргүүн морийг багтаасан “айргийн тав”-ын цолыг тус тус тун бага ялгавартай дууддаг. Зарим газар есдүгээр морь хүртэл дуудах ч бий. Харин дээр жишээлсэн нэгээс есдүгээр морийг нэршүүлэн цоллох талаар газар газрынхан адилгүй. Үүнд, *Наран мандал* гэдэг нэршүүлсэн цол зарим газар хоёр гуравдугаар моринд өгч байхад, зарим газар барданы тасалбар болсон морийг нэрлэж байдаг (1994:723-724). Мөн эрдэмтэн Л.Түдэв “Энэ зууны эхээр долоон хошуу даншиг наадамд уралдсан хурдан хүлэг морьдын эхний хорин нэгэн моринд цол олгодог байжээ. Гэтэл одоо тэр хорин нэгэн цолоос ганцхан нь буюу түрүүлсэн моринд *Түмэн эх* гэдэг цол олгох биш зөвхөн л “сонсгоод” орхидог болчихсон ажээ...

Хоёрт ирсэн моринд *Манлай баярлах дэлгэрэнгүй начин*

Гуравт ирсэнд *Өлзийт дэлгэрэнгүй сайн төгс*

Дөрөвт ирсэнд *Шамдал түрүү хүрэлдэй бүргэд*

Тавд ирсэнд *Идэр хурдан харцага*

Зургаад ирсэнд *Алтан сандал*

Долоод ирсэнд *Тод магнай*

Наймд *Төвийн ширээ*

Есд *Өлзийт хүлэг*

Аравт *Баатар зоригт*

Арван нэгд *Ширээ суух*

Арван хоёрт *Сонин мандал*

Арван гуравт *Бат өлзийт*

Арван дөрөвт *Идэр буга*

Арван тавд *Эрдэнэт эрх хүлэг*

Арван зургаад **Улам өрнөх**
Арван долоод **Гандар**
Арван наймд **Түмэн баяр**
Арван есөд **Хүүхэн чагчгай**
Хорьд **Улам баяялах**

цол тус тус шагнан хайлаж байжээ.

...1906 онд Богдыг даншиг наадамд түрүүлсэн морьдод хайллан шагнасан цол гүншинг ажиглахад түрүү үеийн сонин сайхан үгс их л цөөрч ядуурсан хэдий боловч морьдын нас, шүдээр оноосон тодорхой цолууд хэрэглэсээр байсан нь илэрхий. Түрүүлсэн азарганд Эрхийн цогийг бадруулжс, чандманийн сорыг оргилуулсаар, сонин бардаад ирэгч, тод манлай, тортон жолоо, баярын манлай, бат идэр, түмэн эх, эрдэнэт хүлэг, түрүүлсэн хязааланд Санасаар сонин бадраад ирэгч, хий хянга хэтийн тэмцэл, аглагийн бараа, агтын тэргүүн, баярын манлай, бат идэр, түмэн эх гэдэг цол хайлаж байжээ. Энэчлэнгээр их нас, соёлон, тэр ч байтугай жороо моринд ч тусгай цолтой байсан гэдгийг уул морьдын эзэд үе дамжин хадгалагдаж ирсэн өргөмжлөл бичгүүд гэрчилж байна” (2002:264-265) хэмээн морины цолны өөр нэг хувилбарын тухай дурджеэ.

Нийгэм цаг үе, нутаг нутгийн онцлогоос шалтгаалж цол өгөх нь өөр хоорондоо ялгаатай, зарим нутагт гуравт хурдалсан моринд өгдөг цолыг зарим нутагт айргийн тавд хурдалсан моринд өгдөг байх жишигтэй. Ер нь баахан мартагдаж холилдон хутгалдсан байх шинжтэй тул яг энэ талаар илүү нарийн харьцуулан нягталж шинжлэх шаардлагатай байна. Тухайлбал: *Алтан сандал* цолыг Х.Нямбуу гуайнхаар 9-д, Л.Түдэв гуайнхаар 6-д, Дамбийжалцан гуайн номд өгүүлснээр адаг сүүлд ирсэн моринд өгдөг гэжээ.

Моринд чимэг өгөх талаар эрдэмтэн Ц.Шагдаргочоо “Улсын буюу орон нутгийн наадмын хурдан хөлгийн уралдааны барианд орсон морьдод дор дурдсан цол, чимэг олгодог заншил дээр үеэс уламжлан иржээ. Үүнд:
Уралдаанд түрүүлсэн морь, дэд моринд олгох чимэг:

Нэгдүгээр моринд

1. Нисэн гүйцэж, иэмэн хурдалдаг хөлөг
2. Жимст хангайн жаргалт хөлөг
3. Хүйд гүйцхгүй хурдан хөлөг
4. Харилтгүй хурдан хандгайн буга
5. Агтын түрүүнд гүйдэг армаг хөлөг

Хоёрдугаар моринд

1. Улс төрийн улаан суунаг
2. Сайн төрийн сааршгүй хөлөг
3. Эзэн төрийн итгэлт хөлөг
4. Бат төрийн баходалт хөлөг
5. Хувьсгалт төрийн хурдан хөлөг

гэх мэт эдгээр 10-н цол чимгийг үзүүр түрүүний байранд орсны дараа хурдалсан морьдод олгоно.

Бодлын алдарт дүүлэгчийн хувийн хүчин наардаж хүчинчилж байгаа болдог. Гэвэл энэчүүдийн моринны цолыг уяа эзийн иэрээр дуудна. Төргүүг тахан морийн авар гурав зргүүлийн

Айргийн тавд ирсэн морьдод олгох чимэг

1. Айрагдаж ирсэн агсан хөлөг
2. Тавд ирсэн тайган шинжит хөлөг
3. Ахиж хурдлах алдарт хөлөг
4. Дээшээ ахихаар дэгдэгч хөлөг
5. Ижлээсээ тодорсон эрдэмт хөлөг

ГЭХЧЛЭН ЭДГЭЭРИЙГ АЙРГИЙН ТАВД УДАА ДАРААЛАН ИРСЭН МОРЬДОД ОЛГОНО.

I, II, V ТАСАЛГААНД БАРИГДСАН МОРИНООС БУСАД БАРИАНД ОРСОН МОРЬДОД ОЛГОХ ЧИМЭГ

1. Бууршгүй хурдан хөлөг
2. Маш үзэсгэлэнт мяцашгүй хурдан хөлөг
3. Ширүүн сум шидрүүн давхиат хөлөг
4. Харайлт ихтэй хандгайн зоот хөлөг
5. Газрын холд саардагтгүй хурдан хөлөг
6. Тонж тоорой, торгон жолоо хөлөг
7. Дуут мөндөр дуйлин харцага хөлөг
8. Эзнээ баясгагч эрэмгий хөлөг
9. Түмний баясталан, төгс хурдан хөлөг
10. Шуурашгүй нэмэх шандаст хөлөг
11. Өнөд хурдлах өлзийт хөлөг
12. Шударч ирдэг шувуун хөлөг
13. Дайрч ирдэг даян хөлөг
14. Хурдны шинж нь тодорсон хөлөг
15. Салхинд гүйцэгдэшгүй сайн хөлөг
16. Морьдын түрүүн мохоншгүй хөлөг
17. Агтны манлай алдарт хөлөг
18. Улам хурдлах өрнөх хөлөг
19. Бүдэрч үзээгүй шөрмөст хөлөг
20. Цог нэмэх цойлогч хөлөг
21. Онцгой хурдан, олныг баясгагч хөлөг
22. Хөнгөн сум, мөнгөн зэв хөлөг
23. Ширүүн мөндөр, ширмэн туурайт хөлөг
24. Барианд гүйцэгдэшгүй баходам хөлөг
25. Тод магнай торгон жолоот хөлөг

ГЭХ ЗЭРЭГ ЭДГЭЭР ЧИМГИЙГ ОЛГОХДОО¹ ТУСГАЙ ҮНЭМЛЭХ ДЭЭР ЗААВАЛ БИЧИЖ ӨГНӨ (ШАГДАРГОЧОО, 1961:50-52) ХЭМЭЭЖЭЭ.

Эдгээр баримт, судалгаанаас үзэхэд монголчууд ажны хурдан хүлэгтээ цол, чимэг олгодог байсан нь маргаангүй бөгөөд ийнхүү хурдны моринд цол чимэг олгож ирсэн уламжлал хэдий үеэс тогтолцож хэдий үеэс балархайшиж мартагдав гээд олон сонирхолтой асуулт ундарна.

¹ 6-д ирсэн моринд гуравдахь чимэг олгох ба эдгээрээс хойш ирсэн моридод 4-өөс хойших чимгийг дэс дараагаар олгох бөгөөд 25-аас хойш барианд орсон морьдод чимэг олгохгүй зөвхөн барианд ирсэн гэдэг үнэмлэх олгоно.

Галдан туслагчийн “Эрдэнийн эрих” хэмээх түүхэн сурвалжид: *Мөн онд (1696) Ойрадын Галдан Бошгот хэмээх оргож үхээд, Халхын гурван хан ван, бэйл, бэйс, тайж нар өөр өөрийн суусан нутагт буцаж, хуучин хэвээ байгуулан, чуулган нийлж, найр наадам бэлэглэхүйд, Бонхор донир ганц морио уяж, олон морь лугаа уралдаж түрүүлсэнд, Дархан чин ван бээр магтаж, Түмний эх хэмээх шүлэг зохиогоод, найрт хөгжим барьж, найр наадмыг үүсгэжээ* (Галдан, 2006:211) хэмээн өгүүлсэн баримтаас үзэхүл 1696 оны үеэс эхлэн уралдааны моринд цол чимэг өгч эхэлсэн байна. Улмаар Бат оршил (даншиг) өргөх наадам өргөн дэлгэр тэмдэглэх болсон цагаас эхлэн моринд цолчимэг олгох нарийн ёс тогтжээ. Харин энэхүү зан үйл, уг хэллэг нь Бат оршил (даншиг) өргөх наадам хийхийг хориглох (1912) болон уламжлалт шашин соёлыг хавчин гадуурхах гадны бодлого хүчтэй нөлөөх болсон үеэс хойш буюу 1920-30 оны үеэсгээгдэн мартагдсанболов уу хэмээн таамаглаж байна. Нөгөөтэйгүүр 1960-аад оноос хойш, ялангуяа сүүлийн 30 орчим жил монгол адuu, хурдан морины талаар ном бүтээл арвин их гарсан боловч энд хурдан морины цол, чимгийн талаар бараг дурдаагүй байгаа нь үүний нэг баталгаа болой. Гэхдээ энэ зан үйл, уг хэллэг бүр ор тас мартагдсан уу гэвэл бас угүй байна. Тухайлбал: Хуучнаар Сайн ноён хан аймгийн Сэцэн чин вангийн хошуу одоогийн Архангай аймгийн Чулуут, Өндөр-Улаан, Их Тамир зэрэг ихэнх сумын нутгаар хурдан морины уралдаанд айрагдсан болон тасалгаанд ирсэн морьдод **чимэг өгдөг ёс** хадгалагдан үлджээ. Чингэхдээ: Айрагдсан, тасалгаанд ирсэн морьдын цолыг дуудахаас өмнө наадмын асарт сууж буй нутгийн ахмад буурал юмуу аль эсвэл алдарт уячдын төлөөлөл нэг хүн моринд чимэг өгнө. Түрүү морины эзэн-уяач морины жолоог хусуур сойзны хамт баруун гартаа атган гарана өргөөд зүүн өвдгөөрөө өвдөглөн хагас бохирч суугаад (Зураг №1)



- *Түрүү морины чимэг авья*
 - гэнэ. Чимэг өгч буй хүн:
 - *Хаанахын хэний морь өз?* - гэхэд, Уяач:
 - *Архангай аймгийн Чулуут сумын Зуунмод багийн малчин Баттулгын морь oo* - гэхэд
 - *Жимиин улаан туулай Жигүүртэн бор харцага Түмэн эх идэрайзам*
- гэх мэтээр чимэг өгөхөд уяач -Баярлалаа гэж хэлдэг ёстай. Ийнхүү 1-5 болон тасалгаанд хурдалсан морьдод чимэг олгоно. Чимэг олгоходо хэдэд хурдалсан, ямар зүс, ямар бие

галбиртай зэргээс шалтгаалж морь бүрт ялгаатай байсан бол одоо чимэг үг өгч буй хүний мэдэхийн хэрээр хэддүгээрт хурдалсан, ямар зүсэм зэргийг үл харгалзан өгдөг болжээ². Одоо өгч буй чимэгт:

Хунгийн жигүүр

Хулангийн тоос

Түмэн эх идэрайзам

Жимиийн бор туулай

Жигүүртэн бор харцага

Түмэн эх идэрайзам

Ширүүн мөндөр

Ширмэн туурай

Түмэн эх идэрайзам

Халин дүүлэгч

Хангайн буга

Түмэн эх идэрайзам

Дайрч ирсэн даян хөлөг

Давхиж гарсан хангайн буга

Түмэн эх идэрайзам

Засаг төрийн зандан ширээ

Түмэн эх идэрайзам

Энэ жилийн тасалгаа

Ирэх жилийн түрүү

Түмэн эх идэрайзам

Энэ жилийн баян ходоод

Ирэх жилийн түмэн эх идэрайзам

Энэ мэт одоо өгч буй зарим чимэг нь Ц.Шагдаргочоо гуайн тэмдэглэсэнтэй өрөнхийдөө таарч байна. Харамсалтай нь мартагдсаар, эрэмбэ дараалал нь мөн алдагджээ. Ташрамд дурдахад, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар Л.Түдэв гуайн “Хэрвээ Даяар дуурсагдах далаий даян аварга гэх мэт цол гунишингий нь хасаж орхисон бол аваргууд эхлээд гомдол тавихаас урдаар бөхийн хорхойтнууд бөөн хэрүүл үүсгэн заргалдах нь маргаангүй. Тэгвэл түүний эх, сургийн сор болсон хурдан морьдынхао уламжлалт цол гунишинг ямарваа шийдвэр, хууль дүрэмгүйгээр хасаж گанцхан “Түмэн эх” гэдэг угийг үлдээчихсэн байхад хэн ч “хар цагаан таг” байсаар өдий олон оныг элээсэн нь гайхалтай” (2002:264) гэсэн үгтэй бүрэн дүүрэн санал нийлж байна.

Нөгөөтэйгүүр уг зан үйл Богдын тамгатай хутагт Шива Ширээтийн нутгаар хүчтэй дэлгэрч өнөө хүртэл хадгалагдан үлдсэн мөн хурдан морины хүүхдэд “Мэгзэм”, Ум марзай мам суухай зэрэг тарни цээжлүүлдэг байсан зэргээс хараад энэхүү уламжлал нь яах аргагүй Магсаржав Хурцын өгүүлсэнчлэн Бурханы шашны дэлгэрэл, шашны (Бат оршил өргөх даншиг наадам) ёстой холбоотой болох нь тодорхой байна. Цаашид энэхүү уламжлалыг зөвхөн бус

² Аархангай аймгийн Чулуут сумын харьяат аймгийн алдарт уяач Б.Намиширай, Ч.Жамбалнямбуу нараас тэмдэглэж авав.

нутагт төдийгүй аймаг, улс даяар нэвтрүүлж, цол чимгийн эрэмбэ дарааллыг нарийн тогтоон бүртгэлжүүлж үнэмлэхжүүлж өгвөл өнөө цагийн уяачдын хөдөлмөр зүтгэлийг бодитоор үнэлэх тоомоохон гарц төдийгүй уяачдын нэгдэл холбоо уралдааны морьдын чадал чансааг харуулах гол үзүүлэлт болох нь дамжигтгүй.

Ер нь морины цол чимэг нь бөхийн цол чимэгтэй адил өөр хоорондоо хэлбэр агуулга (үүрэг)-ын хувьд ялгаатай юм. Морины цол³ нь голдуу үгсийг холбох, хорших маягаар бүтсэн уран яруу нийлмэл үгс байна. Энэ нь адuu малын оноосон нэрийн зүйлд хамаарахын зэрэгцээ монгол хэлний хэрэглээний сонин баримт болно. Эдгээрт монгол уламжлал соёл, сэтгэлгээний өвөрмөц нандин зүйл агуулагдаж буй болно. Тухайлбал: 19-т хурдалсан моринд өгдөг цол “Хүүхэн чагчгай”-г өнөөгийн хүүхэд залуус ойлгохгүй байх, уул нь хурдан хүлгийн гангани гоёмсог шинж, дүүлэн нисэх хурдыг шаазгай шувуутай зүйрлэж буй бөгөөд хэлний боломж хязгааргүй харуулсан хэллэг. Харин судлаачид морины чимгийн зүйлийг магтаал буюу “монгол хүний бэлгэдэлч зан сэтгэлгээ болоод үгийн ид чадалд итгэх үзлийн илэрхийлэл болох зан үйлийн учир зорилго бүхий мэргэжлийн аман яруу найргийн зүйл” (Дулам, 2005:59)-д хамруулан судалж ирсэн. Морины чимэг нь зан үйлийн магтаал шүлгийн өвөрмөц нэг хэлбэр юм. Тухайлбал:

Шиরүүн мөндөр

Ширмэн туурай

Түмэн эх идэрайзам

гэхэд эхний мөрөнд хурдан хүлгийнхээ хурдыг байгалийн хурд хүчтэй үзэгдэлтэй, 2-р мөрөнд хурдан хүлгийнхээ хөл туурайн хурд хүчийн цуцаж няашгүйг бэлгэдэн бат бөх төмөртэй зүйрлэн шүлэглэсэн сонирхолтой юм. Ингэхдээ *хандгай, буга, хулан, туулай* зэрэг араатан; *харцага, начин, шонхор, тас, бүргэд, хун, чагчгай (шаазгай), томь* зэрэг жигүүртэн; *салхи, мондор, хуй, шуурга* зэрэг байгалийн үзэгдэл; *сум, зэв* зэрэг эд юмсаар зүйрлэн нэрлэжээ. Мөн *сандал, ширээ, түшилэг, мандал* хэмээж буй нь бат бөх, аюул осолгүйг бэлгэдэж байна.

Профессор С.Дулам “Хурдан морийг бас бөхийн адил начин, шонхор, заан, арслан болгодог бөгөөд гагцхүү урвуу тийш нэрлэдэг аж. Өөрөөр хэлбэл, бөхөд цолны энэ дараалал хамгийн хүчтэй тийшээ өсч байхад моринд бол эсрэгээрээ байдаг шүү” (2005:59) гэсэн сонирхолтой ажиглалт хийсэн байдаг. Үнэхээр хамгийн хурдан морио жигүүртэн шувуутай жишсэн зүйл харагдаж байна. Эдгээр үг хэллэг нь зарим хүнд зөвхөн морь уядаг хэдэн хүнд хамаатай мэт явцуу ойлгогдож магад ч эх хэлнийхээ хэрэглээний энэ мэт өв санг танин мэдэж, үг холбоо уламжлалт арга, үлгэр жишээ найруулгаас суралцах, сэргээн хөгжүүлэх, сурталчлан таниулах эрхэм үүрэг хүн бүхэнд ногдох буй за.

Дүгнэлт

Монголчууд эртнээс морь уралдах, бөх барилдах, сур харвахыг “Наадам” хэмээн нэрлэн өргөн дэлгэр тэмдэглэдэг бөгөөд түүхийн явцад энэхүү баяр ёслол нь ямар нэг байдлаар өөрчлөгдөн хувьсаар иржээ. Ийнхүү, нийгэм цаг үтэйгээ хөл нийлүүлэн өөрчлөгдөн шинэчлэгдэх нь жам ёсны үзэгдэл боловч үндсэн мөн чанарыг хадгалах ёстойг умартаж огт болохгүй. Өөрөөр хэлбэл, аливаа уламжлалд шинэчлэгдэж болох зүйл, гээж үл болох зүйл гэж бий билээ. Эдгээрийн нарийн зааг ялгааг тогтоохгүйгээр, ойлгохгүй хандсанаас болж зарим нэг ёс уламжлал-биет бус өв будгэрч, аажмаар устаж алга болох эрсдэлтэй байна. Үүний нэг нь хурдан морини цол, чимэг хэмээх монгол хэл соёлын сонин сайхан баримт туршлага юм. Эдгээрийг сэргээн хөгжүүлэх нь эх хэлийг дархлаажуулах бас нэг арга хэмээн үзэж байна.

³ Дууддаг цол биш.

Номзүй

Дулам С. Магтаалын аялгуут аман яруу найраг. Чой.Лувсанжавын нэрэмжит хэл иргэншлийн дээд сургуулийн Эрдэм шинжилгээний бичиг-IV. Уб., 2005.

Далай Ч. Юань гурний үеийн монгол (ХIII зууны II хагасаас XIV зуун). Уб., 1973.

Дамбийжалцан. Монгол зан үйлийн зүй. Хөхтөн, 1994 (монгол бичгээр).

Галдан. Эрдэнийн эрих хэмээх түүх болой. Монгол бичгээс хөрвүүлж, эхүүдийг харьцуулан тулгаж, оршил бичин, тайлбар хийсэн Ж.Гэрэлбадрах, Д.Бүдсүрэн, П.Бямбаорол. Монгол түүхэн сурвалж бичгийн цуврал. Уб., 2006.

Магсаржав Хүрц. Долоон хошуу данишг наадам. Уб., 1960.

Түдэв Л. Цолоо хасуулавч хурдаа сааруулаагүй монгол морьд мину зэ. Л.Түдэв. Бүтээлийн чуулган-XV. Уб., 2002, х.264-265.

Шагдаргочоо Ц. Эрийн гурван наадмын яруу найргийн эмхэтгэл. Найруулан засагч Д.Даржаа, Б.Содном. Уб., 1961.